



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/185

Мандалговь

Сар шинийн баярт зориулсан
шагайн харваанд дэмжлэг
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.4.1.2, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.1.1, 2.2.1.1.4 дэх заалтууд болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 16 -ны өдрийн 03 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. XVII жарны "Үзэсгэлэн болгогч" хэмээх харагчин туулай жилийн сар шинийн баярыг тохиолдуулан аймгийн Шагайн харвааны салбар холбооноос зохион байгуулах үндэсний шагайн харваанд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Холбогдох зардлыг хавсралтаар баталсугай.

3. Дэмжлэгт шаардагдах 3,382,000 (Гурван сая гурван зуун наян хоёр мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван), ерөнхий санхүүч (С.Адъяасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100483